



НИЙСЛЭЛИЙН  
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

Ажил эрчимжүүлэх тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргатай байгуулсан 2014 оны үр дүнгийн гэрээний дагуух төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлж, бодит биелэлтийг нэмэгдүүлэх 20 хоногийн аяныг 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 12 дугаар сарын 12-ны хооронд зохион байгуулсугай.

2. Аяны хугацаанд гүйцэтгэх баримт бичиг нэг бүрт явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлж, бодит биелэлтийг нэмэгдүүлж, үр дүн гаргаж ажиллахыг нийт шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

3. Аяны хугацаанд хийх ажлын төлөвлөгөө гарган үр дүнтэй зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар өдөр тутам ханган хяналт тавьж ажиллахыг ахлах шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

4. Албаны нийт бие бүрэлдэхүүнд энэ хугацаанд уртасгасан цагаар ажиллахыг үүрэг болгосугай.

5. Аяны хугацаанд нийт албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавьж ажиллахыг хүний нөөц, сургалт мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн, /дэслэгч П.Сумъяа/-д даалгасугай.

6. Аяны хугацаанд нийт албан хаагчдыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, дүнг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр илтгэх хуудсаар танилцуулахыг дэд дарга /дэд хурандаа Ч.Оюунцэцэг, хошууч Ж.Нандинтуул/ нарт даалгасугай.

Тушаалыг албаны нийт бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА, ХУРАНДАА



Э.БАТБАЯР

200725052556

2014 tushaal